



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/332

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "б", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 10/06 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ховд аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын ширээ, сандлын шинэчлэл ажлыг гүйцэтгэгч "Улаанбүрд" ХХК-ний ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Даваадорж – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Энхмандал – Аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

Д.Нямдорж – Боловсрол, соёл, урлагийн газрын төсөв, хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн

Б.Түмэнжаргал – Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Ж.Батбаяр – Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

2. Ховд аймгийн ЕБС-ын сурагчдын ширээ, сандлын шинэчлэл ажлыг захиалагчаас баталсан техникийн тодорхойлолтын дагуу шалгаж хянан баталгаажуулж, шийдвэр гаргахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

*Түмэнжаргал*

Т.ЖАРГАЛСАЙХАН



02 01455

D/Zax-A/332-Da